Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь Мал амьтны эрүүл мэндийн эрүүл мэндийн тухай хууль болон малын эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого чиглэлийг хэрэгжүүлэх, улсын хэмжээнд мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон хашаа байр, тэжээл, ус, хөрс, ургамалд ариун цэвэр эрүүл ахуйн үзлэг, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, баталгаажуулан гэрчилгээ олгох, орон нутгийн мал эмнэлгийн шинжилгээний байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангахад оршино.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мал амьтны элдэв халдварт өвчнийг оношилж илрүүлэх, шинжлэн эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, чанарын үнэлгээ хийх, хяналт тавих
- Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд үзлэг шинжилгээ хийж дүгнэлт гаргах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар даатгуулагч болон ажил олгогчоос төлөх шимтгэлийн өөрчлөлт;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх өөрчлөлт орсон байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн удирдлага санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн



баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,127,291.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 62,545.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материалын байдлын түвшинг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 3,451,735.1 мянган төгрөгийн 2 хувиар тооцож 69,034.7 мянган төгрөгөөр тогтоолоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,204,711.1 мянган төгрөгөөр буюу 15,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	109,320.3	2,565.0	-106,755.3
Бараа материал	2,011,955.3	2,551,638.1	539,682.8
Үндсэн хөрөнгө	5,793,028.8	6,564,812.4	771,783.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,914,304.4</b>	<b>9,119,015.5</b>	<b>1,204,711.1</b>
Өр төлбөр	734.6	1,086.0	351.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,913,569.8	9,117,929.5	1,204,359.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>7,914,304.4</b>	<b>9,119,015.5</b>	<b>1204,711.1</b>

Авлага дансны үлдэгдэл 2,565.0 мянган төгрөг болж 106,755.3 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилтийн дансны 2019 оны үлдэгдэл татаас санхүүжилтийн авлага 106,202.0 мянган төгрөг он дамжиж төлбөр хийгдсэн нь шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд 2020 оны 12 дугаар сард үүссэн нийгмийн даатгалын байгууллагад илүү төлсөн 1,986.7 мянган төгрөг 2 ажилтнаас авах цалингийн 578.3 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,551,638.1 мянган төгрөг болж 539,682.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд мал эмнэлгийн ерөнхий газраас зарласан оношлуур, хэрэглэгдэхүүний тендер 2 удаа буцсан бөгөөд тухайн тендер нь 2020 оны 3 дугаар улиралд шалгарч, нийлүүлэлт нь 3,4-р улиралд хийгдсэн мөн covid-19 цар тахлын улмаас хөдөө орон нутагт хийгдэх тандалт судалгаа шинжилгээний ажлууд хойшлогдсоноос шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд эм боох материал 2,056,947.1 мянган төгрөг буюу 80,6 хувийг эзэлж байна. Эм боох материалын хадгалах хугацаанд судалгаа хийхэд 1,333,276.0 мянган төгрөгийн материал 12 сар ба түүнээс дээш, 399,754.4 мянган төгрөгийн материал 12 сар хүртэлх, 290,318.3 мянган төгрөгийн материал 6 сар хүртэлх 33,598.3 мянган төгрөгийн материал хадгалах хугацаа дууссан байна. Хугацаа дууссан эм боох материалыг сургалт, судалгааны ажилд хэрэглэдэг гэх боловч энд төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах нөхцөл үүссэн байна.

Үндсэн хөрөнгө төсвийн урсгал зардлын санхүүжилтээс 200,000.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээс 78,065.6 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн /ХХААХҮЯ-ны хөрөнгө оруулалтын санхүүжилтээс/ 1,022,816.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж үлдэгдэл 6,564,812.4 мянган төгрөг болж 771,783.6 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд барилга байгууламж 670,794.8, тээврийн хэрэгсэл 7,000.0, машин тоног төхөөрөмж 81,571.3 тавилга эд хогшил 43,165.6, эм эмнэлгийн хэрэгслийн багаж тоног төхөөрөмж 506,154.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна

Тайлант хугацаанд акталсан, үнэ төлбөргүй шилжүүлсэн, хасагдсан хөрөнгө байхгүй байна. Лабораторийн шинжилгээний программд өргөтгөл, шинэчлэл хийснээс биет бус хөрөнгө 29,000.0 мянган төгрөгөөр өссөн.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 1,086.0 мянган төгрөг болж 351.4 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдын цалингаас суутгасан үйлдвэрчний эвлэлийн холбооны гишүүдийн татварыг тухайн тайлант хугацаанд төлбөрийг хийгээгүй байснаас шалтгаалжээ.

Бусад 734.5 мянган төгрөгийн өр 2018 оноос өмнө үүссэн эзэн холбогдогчийн хаяг, байршил, төлбөрийн нөхцөл нь тодорхойгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,117,929.5 мянган төгрөг болж 1,204,711.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,684,407.2 мянган төгрөгөөр буюу 56.6 хувиар өссөн байна.

Өөрийн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 307,480.4 мянга төгрөгөөр өссөн нь Монгол Улсын Засгийн газрын дунд, урт хугацааны бодлого, стратеги”, “Алсын хараа-2050” зэрэг бодлогын баримт бичигт Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тулгуур салбарын нэгээр ХАА-н салбарыг тодорхойлж, “Хүнс экспортлогч” орон болох зорилгын хүрээнд махны экспорт нэмэгдсэн, хөрөнгө оруулалтын санхүүжилтээр барилга угсралт их засварын ажил хийгдсэнтэй үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос 1,104,051.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь холбоотой байна.

Урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оноос 325,762.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Тайлант онд лабораторийн багаж, техник хэрэгслийн шинэчлэлт хийхээр 200,000.0 мянга, тэтгэвэрт гарах 2 эмч ажилтны тэтгэмж 61,327.1 мянга, лабораторийн шинжилгээний программ хөгжүүлэлт хийгдэх ажилд 45,510.0 мянган төгрөгийг нэмж батлуулсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 285,034.3 мянган төгрөгөөр буюу 9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс зардал өссөн нь цалин хөдөлмөрийн хөлс 115,028.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн, мөн давсан орлогын урамшууллаас шаардлагатай тавилга хэрэгсэл,

өргөтгөлийн барилгад ажилчдын цайны газрын тоног төхөөрөмж авсан, засварын зардал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 2,661,596.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийг төсвийн захирагчийн хүргүүлсэн төслөөс 881,746.4 мянган төгрөгөөр бууруулж 1,779,850.5 мянган төгрөгөөр баталсан нь байна. Үүнээс үзвэл төсвийн захирагчийн төсвийг бодитой төлөвлөөгүй гэж үзэхээр байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Мал аж ахуйг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,779,850.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,694,364.3 мянган төгрөгийг улсын төсвөөс 178,594.4 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,590,107.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 552,474.8 мянган төгрөг, нийт 2,142,582.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,639,661.7 мянган төгрөгийг зарцуулж 249,223.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, тайлант үеийн үндсэн үйл ажиллагааны давсан орлогыг сангийн яамаар хянуулж 253,697.7 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээр авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,639,661.7 мянган төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 37,629.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2,756.7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлыг 11,214.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Мал эмнэлгийн ерөнхий газраас “Шуурхай дуудлага үйлчилгээний зардал”, “Бруцеллёзын хээлтүүлэгч тандалт”, “Мал эмнэлгийн эмийн хяналтын үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхлэх зэрэг зардлуудад нийт 564,538.6 мянган төгрөг, БНСУ-ын WONKWANG их сургуулиас Шувууны томуу өвчинг судлах төсөл, Мерси кор Монгол Интернейшнл ТББ-аас Сумдын малын эмч нарын чадавхийг сайжруулах сургалт, Эйл Би Эйч технологи ХХК-аас хулганы туршилтын ажлуудын санхүүжилт 78,661.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болгосон нэмэлт орлого 253,697.7 мянган төгрөг нийт 896,897.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 130,645.4 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 15,842.00 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 35,419.3 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 136,806.1 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 149,107.6 мянган төгрөгөөр, томилолт зочны зардлыг 23,406.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний

төлбөр хураамж зардлыг 301,674.3 мянган төгрөгөөр, Бараа үйлчилгээний бусад зардлыг 2,400.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшуулал зардлыг 50,000.0 мянган төгрөгийг зарцуулж, гүйцэтгэлээр нийт 845,300.8 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 51,596.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 263 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, хугацаа хоцроосон 130 мэдээлэл, 26 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 9,297.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлагыг өгсөн нь хэрэгжилт нь 82 хувьтай байна. Аудитаар өгсөн санхүүгийн программ хангамжийг сайжруулах зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	9,297.4	2	8,562.8		734.6	82
Зөвлөмж	1	00	1	00	0	0	100
Нийт дүн	3	9,297.4	3	8,562.8		734.6	82

Хэрэгжүүлээгүй албан шаардлагад хамааралтай Сантех ХХК-д өгөх 734.9 мянган төгрөг нь 2018 оноос өмнө үүссэн тухайн байгууллагын байршил хаяг нь тодорхойгүй байна. Албан шаардлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хан-Уул дүүргийн татварын хэлтэст албан тоотоор хандсан боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 206,296.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 194,799.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,991.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчилд албан шаардлага өгч, 3,505.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Үнэ төлбөргүй хүлээн хүлээн авсан орлого, бусдаар гүйцэтгэсэн ажил үйлчилгээ, татвар хураамжийн зардлыг 194,799.8 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав.

## **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 11,496.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 7,257.2 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэх, 734.5 мянган төгрөгт төлбөрийн акт тогтоож хүргүүлээ. Үүнд:

1. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2020 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн №101/Ш32020/16949 тоот захирамж, ШШГЕГ, НШШГГ-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 4-164/38120 тоот шийдвэрийн дагуу 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр “Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори”-иос НШШГГазрын Төрийн банкин дахь 106000059575 тоот дансанд иргэн Д.Батчулууны ажилгүй байсан хугацааны цалин, тэмдэгтийн хураамжийн хамт 7,257.2 мянган төгрөг шилжүүлсэн. Энэ нь “Төрийн албаны тухай хууль”-ийн 50.1-д заасан заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх албан шаардлагыг хүргүүлсэн.

2. Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 263 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, хугацаа хоцроосон 130 мэдээлэл, 26 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

3. Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2019 оны аудитын тайлангаар Сантек ХХК-д өгөх 734.5 мянган төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулах, төлбөр барагдуулах талаар албан шаардлага өгсөн. Албан шаардлагыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сантек ХХК-ийн хаяг байршлыг тогтоох зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хан-Уул дүүргийн татварын хэлтэст албан тоотоор хандсан боловч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эзэн холбогдогч нь тодорхой өглөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

## **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 3,505.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав. Үүнд:

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн эм, боох материалын үлдэгдлийн өсөлт нь 2021 оны худалдан авах ажиллагаа, төсвийн санхүүжилтэд нөлөөлөх байдал, байх ёстой үлдэгдлийн хэмжээнд баримтлах байнгын болон аюулгүйн нөөцийн норм, тоо хэмжээ тодорхойгүй, хадгалалтын хугацаа дууссан болон хугацаа дөхсөн эм бэлдмэл зэрэг нь анхаарал татаж байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **1. Дотоод хяналттай холбоотой асуудал**

###### **1.1 Илрүүлэлт:**

Ажилчин албан хаагчдын эд хөрөнгө ашиглалтын картаас түүвэрлэн Үндсэн хөрөнгийн тооллогын үр дүнгийн тайлантай тулган шалгахад ашиглалтад байгаа зөөврийн хөргүүр ажилтны эд хөрөнгө ашиглалтын карт дээр тоологдоогүй гэж тэмдэглэсэн ч тооллогын бүртгэл, тооцоо бодсон акт, тайланд тусгагдаагүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж байна.

###### **1.2 Эрсдэл:**

Санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө бодитоор оршин байхгүй, хөрөнгө дутагдах, бүртгэлээр тавих хяналт алдагдах санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

###### **1.3 Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгийн тооллогыг чанартай хийх, тооллогын үр дүнг үнэн зөв тайлагнах хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, тухайн зөөврийн хөргүүрийн байршлыг тодорхойлох, хөрөнгө үрэгдсэн бол холбогдох ажилтнаар төлүүлэх.

###### **1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана..

##### **2. Балансын данстай холбоотой асуудал**

###### **2.1 Илрүүлэлт:**

Бараа материалыг орлогод бүртгэхдээ нэгж үнэ, тоо хэмжээг зөрүүтэй бүртгэсэн байна. Тухайлбал Грийн химистри ХХК -аас худалдаж авсан нэг хайрцаг нь 33,000 төгрөгийн үнэ бүхий 96 хайрцаг хамгаалалтын бээлийг орлогод бүртгэхдээ тоо хэмжээг 1 ширхэг, нэгжийн үнээр бүртгээгүй 3,168,000 төгрөгөөр бөөн дүнгээр бүртгэлд тусгасан байна.

###### **2.2 Эрсдэл:**

Тухайн хөрөнгийн зарцуулалтыг бодит үнэ тоо хэмжээгээр нь бүртгэх, зарцуулалтыг үнэн зөв гаргах боломжгүй болгох хангамжийн материалын өртөг буруу илэрхийлэгдэх удирдлагыг буруу мэдээллээр хангах.

###### **2.3 Өгсөн зөвлөмж:**

Эд хариуцагчийн мэргэжлийн ур чадвар, хариуцлагыг дээшлүүлэх, хөрөнгийн бүртгэл, хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах:

###### **2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:**

Зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж ажиллана. Цаашид алдааг давтан гаргахгүй.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10.-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2021.02.20</b>	Аудитын нэр: <b>Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>САГ-2021/230 /СТА/ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр: <b>Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори</b>	Мянган төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тооллогоор дутагдсан хөрөнгийг үндсэн хөрөнгийн тооллогын тооцоо бодсон акт, тооллогын үр дүнд тайлагнаагүй байна.	337.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б.Золзаяа
3	Төрийн албан хаагчийг үндэслэлгүй ажлаас халсан гэсэн шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн төлбөр төлж төсвийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан байна	7,257.2	Албан шаардлага өгөх	Дарга Нягтлан бодогч	Б.Ганзориг Б.Золзаяа
4	www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулбал зохих 263 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээлэл, хугацаа хоцроосон 130 мэдээлэл, 26 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.	-	Албан шаардлага өгөх	Нягтлан бодогч	Б.Золзаяа
5	Бараа материалын тоо ширхэг, нэгж үнийг нягтлан бодох бүртгэлд буруу бүртгэсэн байна.	3,168.0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б.Золзаяа
6	Өмнөх жилийн аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй	734.5	Төлбөрийн акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	Б.Ганзориг Б.Золзаяа
<b>ДҮН</b>		<b>11,496.7</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 32/АД160063

Улаанбаатар хот

САГ-2021/230/СТД-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори нь Сантек ХХК-д өгөх 734,560.00 төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулах талаар өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого, хийх, зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна"; хуулийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах"; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн өглөг данс дээр байгаа эзэн холбогдогч нь тодорхойгүй 734,560 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн дарга Б.Ганзориг, нягтлан бодогч Б.Золзаяа нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
"АЖУ МЭРГЭН АУДИТ" ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ЭРДЭНЭЗУЛ

Л.НАСАНБУЯН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 118/АД/60062

Улаанбаатар хот

САГ-2021/230/СТД-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих 263 мэдээллээс хугацаа хоцроосон 130 мэдээлэл, мөн 26 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар-т ирүүлэх
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн дарга Б.Ганзориг, нягтлан бодогч Б.Золзаяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
"АЖУ МЭРГЭН АУДИТ" ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ЭРДЭНЭЗУЛ

Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 119/Д0160063

Улаанбаатар хот

САГ-2021/230/СТД-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн №101/ШЗ2020/16949 тоот захирамжийн дагуу ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий иргэнд ажилгүй байсан хугацааны нөхөн олговрын 7,257,208 төгрөгийг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шүүхийн шийдвэрээр ажилтанд олгосон 7,257,208 төгрөгийн төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, алдаа, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар-т ирүүлэх

2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн дарга Б.Ганзориг, нягтлан бодогч Б.Золзаяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
"АЖУ МЭРГЭН АУДИТ" ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.ЭРДЭНЭЗУЛ

Л.НАСАНБУЯН



## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 20 lines.